Бараа, ажил, үйлчилгээ худалдан
авах журмын тавдугаар хавсралт

Техникийн тодорхойлолт

Ангилалтын код: 61.020

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ны ажилтны ажлын хувцас. Ерөнхий шаардлага	БС- 01: 2024
Protective workwear of the “Erdenes Tavantolgoi” JSC. General requirement	

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн захирлын 2025 оны 08 дугаар сарын 19 -ний өдрийн А/315 тоот тушаалаар байгууллагын ажлын хувцасны стандартыг батлав.

Техникийн тодорхойлолт нь энэхүү стандартын дагуу байна. Тус стандартын шаардлага хэсгүүдийг хавсаргав.

ӨДӨР ТУТАМ ӨМСӨХ АЖЛЫН ХУВЦСАНД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

5.1 Ерөнхий шаардлага

a) Өдөр тутам өмсөх ажлын хувцас нь үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэлийг багасгах, урьдчилан сэргийлэх, хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан байна.

b) Өдөр тутам өмсөх ажлын хувцасны өмсгөл хэмжээний ангилал нь компанийн ажилтнуудын биеийн хэмжээг бүрэн багтаасан байна.

c) Өдөр тутам өмсөх ажлын хувцас нь:

- үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн шалтгаан, эх үүсвэр болохгүй;
- хүний эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлэхгүй;
- хүний биед хүрэлцэх хэсгүүд арьсанд аливаа цочроо, шархлаа үүсгэх хурц ирмэггүй, хатуу ширүүн гадаргуугүй;
- хүний биеийн цусны эргэлт, амьсгал боогдуулахгүй, хөдөлгөөнд саад учруулахгүй,хэтэрхий том эсвэл хүнд биш;
- угаалга, химийн цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн явцад үндсэн шинж чанарууд нь өөрчлөгдөхгүй байх ёстой.

d) Өдөр тутам өмсөх ажлын хувцасны тэмдэглэгээ, тусгай тэмдэглэгээ нь MNS ISO 13688 стандартын болон тодорхой нэр төрлийн хэрэгслийн тэмдэглэгээний шаардлагуудыг хангасан байна.

e) Өдөр тутам өмсөх ажлын хувцас нь зориулалт, эдэлгээний хугацааг заасан, ашиглах, арчилах, хадгалах заавартай байна.

f) Өдөр тутам өмсөх ажлын тусгай хувцсыг хүрээлэн буй орчинд хор нөлөөгүйгээр устгана.

5.2 Өдөр тутам өмсөх ажлын хувцасны ангилал

5.2.1

“Эрдэнэс Тавантолгой” ХК -ийн хэмжээнд 5.1-р хүснэгтэд заасан үндсэн нэр төрлийн өдөр тутам өмсөх ажлын хувцсуудыг ашиглана. Эдгээр хувцасны гадаад байдал нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ны захирлын тушаалаар батлагдсан зургийн цомогт үзүүлсэн нэгдсэн загвар, дизайнаар боловсруулсан техникийн зургуудтай тохирч байна.

Энэхүү стандартад заагдаж буй ажлын тусгай хувцсыг ажлын орчноор 1-р хүснэгтэд заасан байдлаар ангилна.

1-р хүснэгт. “Эрдэнэс Тавантолгой” ХХК -ийн ажилтны өдөр тутам өмсөх ажлын хувцас

Хувцасны нэр төрөл	
Дотор орчны	**Гадна орчны**
1. Ажлын цамц 2. Жинсэн өмд 3. Богино ханцуйтай, захтай, сүлжмэл цамц 4. Захгүй, сүлжмэл цамц 5. Өвлийн дулаан цамц	1. Өвлийн хүрэм, өмд 2. Өвлийн комбинезон 3. Ажлын хантааз 4. Зуны хүрэм, өмд 5. Зуны комбинезон 6. Ажлын богино хүрэм /бомбер/

Энэхүү стандартад заагдаж буй ажлын хувцсыг улирлаар нь 2-р хүснэгтэд заасан байдлаар ангилна.

2-р хүснэгт. “Эрдэнэс Тавантолгой” ХХК -ийн ажилтны өдөр тутам өмсөх ажлын хувцасны ангилал, улирлаар

Хувцасны нэр төрөл	
Дулаан улирлын	**Хүйтэн улирлын**
1. Зуны хүрэм, өмд 2. Зуны комбинезон 3. Ажлын богино хүрэм /бомбер/ 4. Ажлын цамц 5. Жинсэн өмд 6. Богино ханцуйтай, захтай, сүлжмэл цамц /поло цамц/ 7. Захгүй, сүлжмэл цамц /поло подволк/	1. Өвлийн хүрэм, өмд 2. Өвлийн комбинезон 3. Ажлын хантааз 4. Өвлийн дулаан цамц /ноосон цамц/

Зуны хүрэм, ажлын цамцыг хүйсээр:

- Эрэгтэй
- эмэгтэй гэж ангилна.

6. ӨДӨР ТУТАМ ӨМСӨХ АЖЛЫН ХУВЦСАНД ТАВИХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

6.1 Өдөр тутам өмсөх ажлын хувцсанд тавих техникийн шаардлагууд

6.1.1 Өмсгөл хэмжээ

Өдөр тутам өмсөх ажлын хувцасны өмсгөл хэмжээ нь ажилтны биеийн хэмжээнд таарч байх ёстой. ISO 3635, MNS ISO 13688:2000 стандартын хэв шинжит галбиртай хүний биеийн хэмжээн дээр үндэслэнэ.

Хувцасны өмсгөл хэмжээг биеийн өндөр, цээжний 3-р бүслүүр гэсэн үндсэн хэмжээсүүдээр тодорхойлно. Шаардлагатай бол нэмэлтээр дүүргэвчийн хэмжээ (бүсэлхийн бүслүүр- эрэгтэй хүнд), өгзөгний бүслүүр- эмэгтэй хүнд), ханцуйны уртын хэмжээг ашиглана (А хавсралт).

“Эрдэнэс Тавантолгой” ХК -ийн ажилтны хувцасны өмсгөл хэмжээ нь 3, 4, 5-р хүснэгтэд үзүүлсэн хэв шинжит галбирын чац, цээжний бүслүүрийн хэмжээнд тохирсон байна.

3-р хүснэгт. Гадуур хувцасны өмсгөл хэмжээ ба биеийн хэмжээ

Хувцасны өмсгөл хэмжээ	Хэв шинжит галбирын чац,см (интервал 6 см)	Чацын хэмжээний хэлбэлзэл, см	Хэв шинжит галбирын цээжний бүслүүр, см (интервал 4 см)	Цээжний бүслүүрийн хэмжээний хэлбэлзэл, см
Эрэгтэй ажилтан				
44	164 170	161-167 167-173	88	86-90

46	164 170 176 182	161-167 167-173 173-179 179-185	92	90-94
48	164 170 176 182 188	161-167 167-173 173-179 179-185 185-191	96	94-98
50	164 170 176 182 188	161-167 167-173 173-179 179-185 185-191	100	98-102
52	164 170 176 182 188	161-167 167-173 173-179 179-185 185-191	104	102-106
54	164 170 176 182 188	161-167 167-173 173-179 179-185 185-191	108	106-110
56	164 170 176 182 188	161-167 167-173 173-179 179-185 185-191	112	110-114
58	164 170 176 182 188	161-167 167-173 173-179 179-185 185-191	116	114-118
60	164 170 176 182 188	161-167 167-173 173-179 179-185 185-191	120	118-122
Эмэгтэй ажилтан				
42	158 164 170 176	155-161 161-167 167-173 173-179	84	82-86
44	158 164 170 176	155-161 161-167 167-173 173-179	88	86-90
46	158 164 170 176	155-161 161-167 167-173 173-179	92	90-94
48	158 164 170 176	155-161 161-167 167-173 173-179	96	94-98
50	158 164 170 176	155-161 161-167 167-173 173-179	100	98-102
52	158	155-161	104	102-106

	164 170 176	161-167 167-173 173-179		

4 -р хүснэгт. Ажлын цамцны өмсгөл хэмжээ ба биеийн хэмжээ

Эрэгтэй ажилтан					
Цамцны өмсгөл хэмжээ	Хүзүүний бүслүүр, см (интервал 1 см)	Хүзүүний бүслүүрийн хэлбэлзэл, см	Гарын урт, см	Цээжний бүслүүр, см (интервал 4 см)	Цээжний бүслүүрийн хэлбэлзэл, см
42	37	36,5-37,5	58 62	84	86-90
44	38	37,5-38,5	58 62	88	86-90
46	39	38,5-39,5	58 63	92	90-94
48	40	39,5-40,5	59 63	96	94-98
50	41	40,5-41,5	59 63	100	98-102
52	42	41,5-42,5	59 64	104	102-106
54	43	42,5-43,5	60 64	108	106-110
56	44	43,5-44,5	60 64	112	110-114
58	45	44,5-45,5	60 65	116	114-118
Эмэгтэй ажилтан					
40	34	33,5-34,5	57 59	80	78-82
42	35	34,5-35,5	57 59	84	82-86
44	36	35,5-36,5	58 60	88	86-90
46	37	36,5-37,5	58 60	92	90-94
48	38	37,5-38,5	59 61	96	94-98
50	39	38,5-39,5	59 61	100	98-102
52	40	39,5-40,5	59 61	104	102-106
54	41	40,5-41,5	59 61	108	106-110

Өвлийн дулаан цамц, сүлжмэл цамцыг 5-р хүснэгтэд үзүүлсэн өмсгөл хэмжээтэйгээр үйлдвэрлэнэ.

5 -р хүснэгт. Өвлийн дулаан цамц, сүлжмэл цамцны өмсгөл хэмжээ ба биеийн хэмжээ

Цамцны өмсгөл хэмжээ		Цээжний бүслүүр, см	Биеийн өндөр, см (интервал 6 см)	Биеийн өндрийн хэлбэлзэл, см
Стандарт	Олон улсын			
Эрэгтэй ажилтан				
44-48	**S**	84-92 96-104	164	161-167

48-50	**M**	84-92 96-104	170	167-173
50-52	**L**	84-92 96-104	176	173-179
52-54	**XL**	88-100 104-116	182	179-185
54-56	**2XL**	92-100 104-116	188	185-191
Эмэгтэй ажилтан				
42-44	**S**	80-88 84-92	158	155-161
44-46	**M**	84-92 92-100	164	161-167
46-48	**L**	88-96 100-108	170	167-173
48-52	**XL**	92-100 108-116	176	173-179

Дээр дурьдсан өмсгөл хэмжээнээс их эсвэл бага үед хэрэглэгчийн биеийн хэмжээний онцлогт тохируулан захиалгаар үйлдвэрлэнэ.

6.2.1 Нийтлэг шаардлагууд

6.2.1.1 Эргономикийн шаардлага

Өдөр тутам өмсөх ажлын хувцасны загварыг дараах шаардлагуудад нийцүүлэн зохион бүтээнэ. Үүнд:

a) Хувцасны хийц нь тухайн мэргэжлийн онцлог, хөдөлмөрийн нөхцөл, биеийн хөдөлгөөнд тохирсон, биед эвтэй, ажлын явцад чөлөөтэй хөдлөх боломжийг хангасан, товчлоос нь өмсөж тайлахад хялбар байна.

b) Хувцас нь өмсөх цаг агаарын нөхцөл, улиралд тохирсон байна.

c) Хувцас нь зохих хамгаалалтын зэрэгцээ хэрэглэгчийн тав тухтай байдлыг дээд зэргээр хангасан байна.

d) Хувцасны зарим бүрдэл хэсгүүдийн хэмжээг хувь хүний биеийн морфологийн онцлогт тохируулан өөрчилж болохуйц хийцтэй байж болно.

e) Хувцас нь эрүүл ахуйн шаардлага хангасан, чийг шингээлт, агаар нэвтрүүлэлт сайтай, өвлийн хувцас нь хүйтнээс найдвартай хамгаалах хийцтэй байна.

f) Хувцас нь хүний эрүүл мэндэд хортой болон тааламжгүй нөлөө үзүүлэхээргүй хийц, материалтай байна.

g) Хувцасны хүний биед хүрэлцэх хэсгүүд арьсанд аливаа цочроо, шархлаа үүсгэх хурц ирмэггүй байна.

h) Хувцасны хийцэд хувцасны дорхи давхаргын бичил цаг уурын хэвийн байдлыг дэмжих элементүүд оруулж болно: хөлс ихээр ялгардаг хэсгүүдэд салхивчны нүх, онгорхой гэх мэт.

i) Өмдний өвдөгний хэсэгт давхарлагыг нээж болохоор зангуутай хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд завсар нь хамгаалалтын өвдгөвчийг хийж ажлыг гүйцэтгэнэ.

j) Цээжний, бүсэлхийн, өгзөгний бүслүүр дээрх чөлөөт хөдөлгөөний сулын тавилтын хэмжээ нь амьсгалах, цусны эргэлт, хувцасны дорхи давхаргын агаарын хөдөлгөөн, биеийн хөдөлгөөний чөлөөт байдлыг хангаж байх ёстой.

k) Хувцасны жин нь ажилтны бие организмд сөрөг нөлөө үзүүлэхээргүй байна.

l) Хөдөлмөрийн багаж хэрэгсэл хийх халаас болон товчлоос, бусад шаардлагатай элементүүд нь оновчтой хэмжээ, байрлал, хийцтэй байна.

6.2.1.2 Хамгаалах шаардлага

a) Хувцасны хийц нь үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлс хувцасны дотор тал руу үсрэх, урсах, нэвтрэх, нэвчихээс дээд зэргээр хамгаалсан байна.
b) Хувцасны хамгаалах чадварыг нэмэгдүүлэхийн тулд үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлсээс хамгаалах шинж чанартай материалаар давхарлагууд хийж өгнө. Хамгаалах давхарлагуудын байрлал, хэлбэр нь хөдөлмөрийн нөхцөлөөс хамаарч, үйлдвэрлэлийн аюултай хортой хүчин зүйлийн шинж чанараар тодорхойлогдоно.
c) Хувцасны гадаргуу нь үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлс тогтохооргүй толигор байна.
d) Хувцасны гадаргууд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжтэй ороцолдох, дэгээдэгдэх бүч, бүс, сойлт гэх мэт бүрдэл хэсгүүдийн сул үзүүр байх ёсгүй.
e) Хувцасны өнгө нь үйлдвэрлэлийн байрны интерьер, гэрэлтүүлэгт зохицсон, машин тоног төхөөрөмжөөс ялгарч харагдах өнгөтэй байна. Хувцас нь алсаас болон гэрэл багатай, харанхуй газарт ажилтны байгаа газрыг мэдээлдэг дохиоллын элементтэй байна. Ажлын цамц, флис цамцны цацруулагчийн өргөн 2,5 см, бусад бүх хувцсанд цацруулагчийн өргөн 5см байна.
f) Аюул тохиолдсон үед шаардлагатай бол тайлахад хялбар байна.

6.2.1.3 Эдэлгээний шаардлагууд

a) Хувцас нь бөх бат, нормт хугацааны туршид хамгаалах чадвараа хадгалах, эдэлгээнд найдвартай (хэлбэрээ хадгалалт, элэгдэлт тэсвэрлэлт сайтай), засварлах боломжтой, шаардлагатай тооны угаалга, индүүдлэгийг тэсвэрлэх чадвартай байна.
b) Ашиглалтын явцад хувцасны материал, оёсон оёдол нь урагдахгүй, элэгдэл болон үйлдвэрлэлийн төрөл бүрийн хүчин зүйлийн нөлөөллийг тэсвэрлэх чадвартай байна.
c) Жинсэн өмдний материалыг угааж болон ууранр боловсруулж агшилтыг багасгана. Материалын дээжийг агшилтын процесст оруулаад агшилтын хувийг тодорхойлсны дараа үлгэр дээр зохих сулын тавилтыг тавьж эсгэнэ.

6.2.1.4 Гоо зүйн шаардлага

a) Хувцасны загвар дизайн, өнгөний шийдлүүдийг хэрэглэгчтэй тохирсны үндсэн дээр өдөр тутам өмсөх ажлын хувцасны орчин үеийн загварын чиг хандлагад болон хэрэглэгчийн таашаалд нийцүүлэн, хувцасны дизайны зарчмуудыг баримтлан боловсруулсан байна.
b) Хувцасны боловсруулалт, шошго, эмблем нь зохих шаардлага хангасан, гадаад үзэмж чанарын шаардлага хангасан байна (6-р хүснэгт).
c) “Эрдэнэс тавантолгой” ХК - бренд хөтөч” баримт бичигт заасны дагуу бүх төрлийн ажлын хувцасны зүүн энгэрт байрлах логоны өнгөний код, хэмжээ, үсгийн фонт ижил байна (1, 2-р зураг).
d) Байгууллагын лого, таних тэмдгийг өвлийн болон зуны ажлын хувцас дээр компьютер хатгамал (утас нь - хатгамлын зориулалттай торгон), эсвэл хэвлэлийн орчин үеийн аргаар (digital textile printing, heat transfer гэх мэт) хийсэн байна.

6-р хүснэгт. Лого, таних тэмдгийн байрлал, өнгө, хэмжээ

Таван уулын дүрслэл болон ЕТТ бичиглэл нь “Эрдэнэс Тавантолгой“ ХК-ийн үндсэн лого юм.	
Хэмжээ, мм (өргөн* урт)	х нэгжийн хэмжээ нь “Е” үсэгний хөндлөн сэртэнгийн зураасны өндөртэй тэнцүү байх ба логоны хэмжээ 15х өндөртэй 41х урттай байна.

Логоны зураг, бичлэг	 1-р зураг
Лого байгуулалт	Уулын өгсөх дараалал нь 9 эрдэнийн билэгдэл болгон 9 градусын өнцөг үүсгэж байгаа.
	 2-р зураг
Байрлал	Зүүн энгэрийн хөндлөн оруулганы оёдлоос дээш 1.0 см зайд, энгэрийн голын оёдлоос 6.0 см зайд байрлана.
Логоны суурь өнгө	Цагаан суурин дээр шар, хар өнгөөр хатгаж оёно. Логог тойрсон хил хязгаарыг логоны өндрийн 2/1 гэж үзэх бөгөөд хил хязгаарыг давуулан дизайны элемент оруулахыг хориглоно.
Ажлын хувцасны арын бүрдэл хэсэг дээрхи бичилт	“Эрдэнэс тавантолгой” бичиглэлийг Danzan Arial фондоор, үсгийн өргөн Bold, үсгийн өндөр 5 см, уртын хэмжээг 29 см-т багтаан хувцасны арын бүрдэл хэсэг дээр бичнэ. Шар өнгөтэй бүрдэл хэсэг дээр хөх өнгөөр, хөх өнгөтэй бүрдэл хэсэг дээр шар өнгөөр тус тус бичнэ.

“Эрдэнэс тавантолгой” ХК-ний лого нь хоёр гол өнгө ашигладаг. Шар, хар өнгийг батлагдсан кодын дагуу гаргана (3-р зураг).

ETT YELLOW

RGB - 251 170 25
CMYK - 0 38 100 0

LAB - 76 23 75
HEX - #faaa18



3-р зураг. Эрдэнэс Тавантолгой ХК-ний логоны тэмдгийн хэрэглээний өнгө

е) Ажилтнуудын ажлын хувцас нь хөх, шар өнгийг хослуулсан байна. Хувцасны өнгөний кодыг 7-р хүснэгтэд үзүүлэв.

7-р хүснэгт. Ажлын хувцасны өнгөний код

№	**Өнгөний нэршил**	**Pantone систем дэх өнгөний код**	**Өнгө**
1	Хөх	Pantone 19-3939 TPX Blueprint	
2	Шар	Pantone 14-1064 TPX Saffron	

6.2.1.5 Хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлага

а) Өдөр тутам өмсөх ажлын хувцас нь ашиглалтын явцад аюултай, хор хөнөөлтэй хүчин зүйл, ослын шалтгаан болохгүй байна.

b) Өдөр тутам өмсөх ажлын хувцас, дагалдах хэрэгсэл үйлдвэрлэх материал нь ариун цэвэр, эрүүл ахуйн үзүүлэлтүүдийн тогтоосон стандартад нийцсэн байна.

c) Хувцасны материал нь хүний биед хортой нөлөө үзүүлдэг хортой хольц агуулаагүй байна. Энэхүү шаардлагыг ажлын хувцас үйлдвэрлэхэд ашигласан материалын аюулгүй талаарх шинжилгээний хуудсаар баталгаажуулна.

d) Өдөр тутам өмсөх ажлын тусгай хувцсыг дахин боловсруулах арга нь байгаль орчинд хор хөнөөл учруулахгүй байна.

е) Гэрэл ойлгогч цацруулагч материалаар тусгай зориулалтын хувцсанд ашигладаг дохионы элементүүд нь тэдгээрт тавигдах шаардлагад нийцнэ.

6.2.2 Бүтээгдэхүүнд ашиглах материалд тавих шаардлагууд

Өдөр тутам өмсөх ажлын хувцсанд ашигласан материал нь тухайн зориулалтын хувцасны хамгаалах шинж чанарыг хангах үзүүлэлтүүдтэй байна.

Мөн хүний эрүүл мэндэд хортой формальдегид, хүнд металл, фенол, хориглосон будаг, харшил өгдөг будаг агуулаагүй, таагүй үнэргүй, хортой бодис ууршуулдаггүй, pH хэвийн байх нэмэлт шаардлага хангасан байна.

6.2.2.1 Гадар материалд тавих шаардлага

Хувцасны гадар материал нэр төрөл, улирлын зориулалтаас хамаарч 8, 9-р хүснэгтийн шаардлагыг хангасан байна. Өвлийн өдөр тутам өмсөх ажлын хувцасны гадар материал нь гадны механик үйлчлэлд тэсвэртэй, гаднаас ус чийг нэвтрүүлэхгүй, хөлддөггүй байна. Салхины хамгаалалтын давхаргын уур нэвтрүүлэлт 4.0 мг/(см*цаг)-аас багагүй байна.

8-р хүснэгт. Өвлийн хувцасны материалын шинж чанарын үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	Хүрэм	Комбинзон, өмд
1	Хиймэл ширхэгтийн бүрэлдэхүүн, %, *ихгүй*	65	40
2	Гадаргуугийн нягт, *г/м², багагүй*	200	230
3	Зузаан, мм, ихгүй	0.6	1.2
4	Тасралтын даац, *Н, багагүй* -суурь утасны дагуу -хөндлөн утасны дагуу	780 650	700 600
5	Будгийн тогтвор, *баллаас дээш* -угаалтанд -нарны гэрэлд	3	3
6	Агаар нэвтрүүлэлт, *дм³ /м² с, ихгүй*	40	40
7	5 удаагийн угаалтын дараах агшилт, *%, ихгүй*	±2.0	±2.0
8	Элэгдэлт тэсвэрлэлт, *эргэлт, багагүй:*	10000	8000

9-р хүснэгт. Зуны хувцасны материалын шинж чанарын үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	Цамц	Хүрэм, өмд, комбинзон	Жинсэн өмд
1	Хиймэл ширхэгтийн бүрэлдэхүүн, %, ихгүй	40%		
2	Гадаргуугийн нягт, *г/м², багагүй*	170	230	290
3	Зузаан, мм, *ихгүй*	0.5	0.7	1.0
4	Тасралтын даац, *Н, багагүй* -суурь утасны дагуу -хөндлөн утасны дагуу	490 255	550 340	785 400
5	Будгийн тогтвор, *балл* -угаалтанд -нарны гэрэлд	3-4	3-4	3-4
6	Агаар нэвтрүүлэлт, *дм³ /м² с, ихгүй*	150	100	100
7	5 удаагийн угаалтын дараах агшилт, *%, ихгүй*	±2.0	±2.0	±2.0
8	Элэгдэлт тэсвэрлэлт, *эргэлт, багагүй:*	7000	6000	8000
9	Формальдегидийн хэмжээ, мг/кг, ихгүй	75	150	

Ажлын богино хүрэм /бомбер/ гадна материал 100% полистер (куртканы зориулалтын материал)-тай байна.

6.2.2.2 Дотрын материалд тавих шаардлага

Хувцасны дотрын зориулалтаар ашиглах материалд 10-р хүснэгтэд заасан шаардлагуудыг тавина.

10-р хүснэгт. Дотрын материалын шинж чанарын үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	Зөвшөөрөгдөх хэмжээ
1	Ширхэгтийн бүрэлдэхүүн, *%, багагүй*	Хиймэл ширхэгт 80-100
2	Гадаргуугийн нягт, *г/м², багагүй*	110
3	Тасралтын даац, *Н, багагүй:* -суурь утасны дагуу -хөндлөн утасны дагуу	 200 150
4	Элэгдэлт тэсвэрлэлт, *эргэлт, багагүй*	6000
5	Чийг шингээх чадвар, *%, багагүй*	7
6	Агаар нэвтрүүлэлт, *дм³/м² с, багагүй*	100
7	5 удаагийн угаалтын дараах агшилт, *%, ихгүй* -суурь утасны дагуу -хөндлөн утасны дагуу	 -3.5 ±2.0
8	Будгийн тогтвор, оноо, дээш -угаалтанд -нарны гэрэлд	4

6. 2.2.3 Хувцасны дулаалгын материалд тавих шаардлага

Хувцасны дулаалганд зузаан болон давхаргын тоогоор шаардлагатай дулаан хадгалах чадварыг хангаж чадах, шаталтыг дэмждэггүй ямар ч төрлийн дулаалгын материал ашиглаж болно. Энд нэхээсгүй дулаалгууд (тэмээний ноос, синтефон, тинсулейт зэрэг төрөл бүрийн ширхэгтээр үйлдвэрлэгдсэн), хөвөн, өд сөдөн дулаалга (дүүргэгч) г.м. багтана.
Дулаалгын материал нь 11-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

11-р хүснэгт. Синтетик дулаалгын материалын шинж чанарын үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр		Үзүүлэлтийн утга
1	Гадаргуун нягт, г/м²		80-200
2	Зузаан, мм, багагүй		30
3	Нягт, Oz/y² / г/ м², багагүй	Ар, энгэрт	10 / 340
		Ханцуй, өмдний бүрдэл хэсэгт	8 / 272
4	Агшилт, % -суурь утасны дагуу -хөндлөн утасны дагуу		±2.5

Бүтээгдэхүүний онцлогт нийцүүлэн сонгосон ширмэл дулаалгын материал 12-р хүснэгтийн шаардлага хангасан байна.

12-р хүснэгт. Ширмэл дулаалгын материалд тавигдах шаардлага

№	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн утга
1	Ширхэгтийн бүрэлдэхүүн	35 % полиэстер, 65 % полипропилен бүхэл ширхэгт, эсвэл 100 % полиэстер
2	Нягт, багагүй	300 г/ м² (синтефон)+ 150 г/ м² (ширмэл өнгө)
3	Хийцийн онцлог	Дотрын материалтай ширсэн
4	Чийг шингээх чадвар, %, багагүй	3

Өвлийн дулаан цамцны флис материал цахилгаанжилтаас хамгаалсан /антистатик/ боловсруулалт хийгдсэн бөгөөд 13-р хүснэгт заасан шаардлагад нийцсэн байна.

13-р хүснэгт. Өвлийн дулаан цамцны флис материалын шинж чанарын үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	Төрөл	
		Нэг талдаа үстэй	Хоёр талдаа үстэй
1	Ширхэгтийн бүрэлдэхүүн, багагүй	Полиэстер 100	

2	Зузаан, мм	1.3	2.5
3	Тасралтын даац, Н, багагүй	200	300
4	Элэгдэлт тэсвэрлэлт, эргэлт, багагүй:	5000	
5	Дулааны эсэргүүцэл, м2 °С/Вт, багагүй	0.18	0.22
6	Агаар нэвтрүүлэлт, дм3/м2-с, багагүй	150	100
7	Будгийн тогтвор, оноо, багагүй: - угаалга - хөлс - хуурай үрэлтэнд - нойтон үрэлтэнд	4 4 4 4	

Сүлжмэл цамцны даавуу пике сүлжээсээр сүлжсэн, арьстай шууд шүргэлцэх 1-р үеийн хувцас тул 14-р хүснэгт заасан шаардлагад нийцсэн байна.

14-р хүснэгт - Сүлжмэл цамцны материалын нийтлэг үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр		Хэмжих нэгж	Үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ
1	Байгалийн гаралтай ширхэгтийн агууламж, багагүй		%	60
2	Хиймэл ширхэгтийн агууламж, ихгүй		%	40
3	Гадаргуугийн нягт, багагүй		г/м^2	170
4	Агаар нэвтрүүлэлт, багагүй		дм^3/м^2 с	150
5	Тасралтын даац, багагүй	суурь утасны дагуу	Н	490
		хөндлөн утасны дагуу	Н	255
6	Элэгдэлт тэсвэрлэлт, багагүй		эргэлт	7000
7	5 удаагийн угаалтын дараах агшилт, ихгүй	суурь утасны дагуу	%	±2,0
		хөндлөн утасны дагуу		
8	Будгийн тогтвор, багагүй	угаалтад	балл	4
9	Формальдегидийн хэмжээ, ихгүй		мг/кг	75

15-р хүснэгт- Бусад үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн утга		
1	Өвлийн хувцасны материал	Хүрэм	Комбинзон, өмд	-
1.1	Урагдалт тэсвэрлэлт, Н, багагүй -суурь утасны дагуу -хөндлөн утасны дагуу	 18 22	 18 22	-
1.2	Тоос үл нэвчилт, баллаас багагүй	4	4	-
2	Зуны хувцасны материал	Цамц	Хүрэм, өмд, комбинзон	Жинсэн өмд
2.1	Чийг шингээлт, %, багагүй	25	5	5
2.2	Тоос үл нэвчилт, балл, багагүй	4	4	4
3	Синтетик дулаалгын материалын шинж чанарын үзүүлэлт	Үзүүлэлтийн утга		
3.1	Жингийн жигд бус байдал, %	±10		
4	Ширмэл дулаалгын материалд тавигдах шаардлага	Үзүүлэлтийн утга		
4.1	Гадрын болон дотрын материалыг дулаалгын ширхэгтийн нэвчин гарах	150 см2 талбайд хоёроос ихгүй ширхэгт		
5	Сүлжмэл цамцны материалын нийтлэг үзүүлэлт	Үзүүлэлтийн утга		
5.1	Чийг шингээлт, багагүй	25%		

Тайлбар:

- 8-14 дүгээр хүснэгтэд заасан үзүүлэлтүүдийг итгэмжлэгдсэн лабораторид заавал шинжилгээнд хамруулсан байх;

- 15 дугаар хүснэгтэд заасан үзүүлэлтүүд нь импортоор нийлүүлэгдэж буй материалыг үйлдвэрлэгч эсвэл экспортлогч улсын лабораторид хийлгэсэн шинжилгээний баримтаар баталгаажсан байна.

6. 2.2.5 Туслах материалд тавих шаардлага

a) Туслах материал болох цахилгаан товч, товч, зангуу нь хүйтэн нөхцөл, хими цэвэрлэгээ, индүүдлэг даах чадвартай байна.

b) Хувцасны туслах тоноглол, оёдлын утасны өнгө нь гадар материалын өнгөтэй зохицсон байна.

6.2.3 Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд тавих шаардлагууд

a) Хувцсыг энэхүү стандартад дурьдсан шаардлагуудад нийцүүлэн батлагдсан эх загвараар техникийн баримт бичигт заасны дагуу үйлдвэрлэнэ.

b) Хувцсанд хатгац, оёдол хийхэд тавигдах шаардлага:

-Хувцасны хатгац, оёдлын төрөл MNS ISO 4916:2011, MNS ISO 4915:2012 стандартад нийцсэн байна.

-Хувцасны бүх оёдол 1,0 см-т 3-3,5 ширхэг хатгацтай байх ба ил оёдол нь тэгш, алгасаагүй, шигээгүй, тунараагүй, муруйгүй байна.

-Хувцасны нэгтгэх оёдлуудын тасралтын ачаалал 250 Н-аас багагүй байна.

-Хувцасны суга, өмдний суудлын оёдол, халаас, мөрний оёдол гэх мэт ачаалалд их өртдөг зангилаа хэсгүүдийн бат бөх байдлыг хангахын тулд нэгтгэж оёхоос гадна хос ил оёдлыг гинжин хатгацтай машинаар оёно.

-Хос оёдол хоорондын зай загвараас хамаарах бөгөөд оёдлын бүх уртын туршид ижил зайд зэрэгцээ байрлана.

-Хувцсанд ашиглах үндсэн болон туслах материалын өнгөтэй зохицсон өнгийн, бөх утсаар оёно.

c) Оёдол бүрийн төгсгөлд зайлшгүй бөхөлгөө хийх ба түүнд тавигдах шаардлага нь:

-Ердийн хатгац (MNS ISO 4915:2012) бүхий оёдлын төгсгөлд буцах чиглэлээр 0,7 см-1,0 см урттай бөхөлгөө хийнэ.

-Гинжин хатгац бүхий оёдлын бөхөлгөөг 1,0 см-д ноогдох хатгацын тоог 10 ширхэг хүртэл нэмэгдүүлэх байдлаар эсвэл оёдлын утсыг 0,5см-0,7см урттайгаар үлдээж хийнэ.

-Битүү оёдлын эхлэл төгсгөлийн бөхөлгөөг оёдлын мөрөн дээр 1,0 см-2,0 см урттайгаар давхарлаж хийнэ.

-Бүх хувцасны халаасны таг, хагалбар болон оёдолд орсон ташуу халаасны эхлэл, төгсгөл, ил халаасны амсар, далд товчлоос, оноо, хагалбар, цахилгаантай болон товчтой өмдний халаа, бүсний сойлт, саалт, түдүүлд тусгай зориулалтын машинаар бөхөлгөө хийнэ.

-Арын бүрдэл хэсэг дээрхи аврах гогцооны бөхөлгөөний харалдаа бүрдэл хэсгийн дотор талд жижиг даавуун давхарлага барьж бөхөлгөө хийнэ.

-Товч, цахилгаан товч хадах, товчны нүх гаргахад тавигдах шаардлага:

-Товчны нүхний уртын хэмжээ уг бүтээгдэхүүнд хадагдах товчны диаметрээс 0,2 см-0,5 см илүү байна.

-Товч хадах, товчны нүх гаргахдаа хоёроос доошгүй давхарласан материал дээр хийж гүйцэтгэнэ.

-Товчны нүхийг заавал тусгай зориулалтын машинаар гаргаж, цоолсон байх ба төгсгөлийг бөхөлсөн байна.

-Товчийг товчны нүхтэй ижил өнгийн утсаар оёно.

-Товчлоосны зориулалттай товчийг зориулалтын машинаар оёно.

-Товч нь ажлын хувцасны өнгө дагуу байх.

-Машинаар хадах үед: товчний нүх болгоныг 12-оос доошгүй хатгацаар оёно.

-Бүтээгдэхүүний ил харагдах бүх зах ирмэгүүдийг боловсруулсан (хэрэх, эмжих г.м) байна.

6.2.4 Хувцасны шошгонд тавих шаардлага

a) Хувцас бүр үйлдвэрлэгчийн нэр, үйлдвэрлэсэн улс, тухайн хувцасны өмсгөл хэмжээ, өмсөх хүний биеийн хэмжээ (биеийн өндөр, цээжний тойрог), материалын ширхэгтийн холио, ашиглалтын заавар (ISO 3758: 2012) мэдээлэл бүхий шошготой байна.

b) Шошго нь сайн харагдах, элэгдэл багатай газар байрлах ба уншигдах боломжтой, гаргацтай байна.

Жич: гадуур хувцасны шошгыг арын дотрын голд хоолойн ухлаадасны шугамнаас доош, өмсгөл хэмжээ, өмсөх хүний биеийн хэмжээ, материалын ширхэгтийн холио, угаалга ашиглалтын заавар мэдээлэл бүхий шошгыг дотрын зүүн талын хажуугийн оёдолд хавчуулж оёхыг; дан хувцасны хувьд дотрын халаасны ирмэгээс доош, өмдний хувьд ар бүсний залгаас оёдолд хавчуулж оёхыг зөвлөж байна.

c) Шошго нь тухайн хувцасны заагдсан эдэлгээний хугацаанд угаалга, цэвэрлэгээг (угаалга, цэвэрлэгээний тоонд тохирох) тэсвэрлэхээр бат бөх байна.

d) Шошго нь хүний арьсыг нухаж холгохгүй, харшил өгөхгүй материалаар хийгдсэн байна.

e) Шошго, зурган тэмдэглэгээ (пиктограмм) нь тоон болон тусгай мэдээллийг хурдан уншиж, зөв ойлгох боломж бүхий хэмжээтэй байна.

Жич: 2 мм-ээс ихгүй хэмжээтэй цифр, хүрээтэйгээ 10 мм-ээс ихгүй хэмжээтэй зурган тэмдэглэгээг (цагаан дээр хараар бичсэн) хийж ашиглахыг зөвлөж байна.

f) Ашиглалтын заавар дараах агуулгатай байна. Үүнд:

- Шаардлагатай тохиолдолд өмсөж тайлах заавар
- Ашиглалтанд тавих хязгаарлалт (өмсөх нормт хугацаа, ашиглалтын дараа устгах заавар г.м)
- Хадгалах, арчлах заавар
- Хувцасны материалын онцлогт тохирсон цэвэрлэгээний заавар (угаах горим, химийн цэвэрлэгээний бодис, индүүдэх температурын хязгаарлалт г.м)
- Нэр бичих шошго
- Угаалгын горим

6.2.5 Хувцасны сав баглаа боодолд тавих шаардлага

a) Хувцас тус бүрийг (хос бол иж бүрдүүлж) тусгай зориулалтын гялгар уутанд савлан, хэд хэдээр нь багцалж хайрцаглана.

b) Үйлдвэрлэгч барааны дагалдах хуудсыг хоёр хувь бичиж, нэг хувийг хайрцагны дотор талд хийж, хоёр дахь хувийг хайрцагны гадна талд наана. Дагалдах хуудсанд бүтээгдэхүүний нэр төрөл, тоо ширхэг, үйлдвэрлэгчийн нэр хаяг, огноог бичсэн байна.

c) Хайрцагны хажуу талд ус, чийгнээс хамгаалахыг анхааруулсан таних тэмдгийг тод өнгөөр тэмдэглэсэн байна.

Нимгэн баган малгайн техникийн тодорхойлолт		
1	**Өнгө**	Хар, хар хөх өнгөтэй эсвэл хосолсон байж болно.
2	**Материал**	Хөлс чийгийг гадагшлуулах боломжтой, сунадаг зөөлөн материалтай байна. Сүлжмэл (нэхээстэй) биш байна.
3	**Үзүүлэлт**	➢ Хамгаалалтын дуулга дотор өмсөх зориулалттай нүд гарсан баган малгай байх ➢ Өмсөх, тайлахад хялбар, эвтэйхэн байх ➢ Угааж хэрэглэхэд агшихгүй, будаг гарахгүй байх ➢ Баг, нүдний шил гэх мэт нэмэлт хэрэгсэлтэй хослуулан хэрэглэх боломжтой байх ➢ Амьсгал авах, гаргах хэсэгт нэмэлт шийдэлтэй байх

		➢ Бүтээгдэхүүнд үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй байх
4	**Зураг**	

Ноосон малгайн техникийн тодорхойлолт		
1	**Өнгө**	Хар, хар хөх өнгөтэй.
2	**Материал**	Хөлс чийгийг гадагшлуулах боломжтой Polyester болон ноосон даавуу материалаар хийгдсэн байна.
3	**Үзүүлэлт**	➢ Хөнгөн, бат бөх давхар оёдолтой, өвлийн зузаан байх. ➢ Сунадаг, зөөлөн материалтай байх. ➢ Угааж хэрэглэхэд агшихгүй, будаг гарахгүй байх. ➢ Компанийн логог малгайн дээр оёсон байх. ➢ Бүтээгдэхүүнд үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, чанарын шаардлага хангасан байх.
4	**Зураг**	

ТУСГАЙ ШААРДЛАГА

1. Ажлын хувцасны энгэр хэсэгт ажилтны нэр, албан тушаалыг дизайны оновчтой байдлаар тогтооно.
2. Тендерт шалгарсан Нийлүүлэгч Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаа овоо багт байрлах Салбарт ирж нийт ажилчдаас хэмжээ авах бөгөөд тус хэмжээст үндэслэн “Эрдэнэс Тавантолгой” ХК -ийн ажилтны хувцасны өмсгөл хэмжээ нь 3, 4, 5-р хүснэгтэд үзүүлсэн хэв шинжит галбирын чац, цээжний бүслүүрийн хэмжээнд тохирсон чац, размерыг гарган хувцсыг үйлдвэрлэнэ. Захиалагч тал энэ үйл ажиллагаанд нэмэлт зардал гаргахгүй болно.
3. Тендерт шалгарсан нийлүүлэгчид техникийн баримт бичиг буюу ажлын хувцас үйлдвэрлэлд шаардлагатай баримт бичиг болон эсгүүрийг өгнө.

Хувцасны өмсгөл хэмжээ тодорхойлоход шаардлагатай биеийн үндсэн хэмжээсүүд



АЖЛЫН ХУВЦАСНЫ ЗАГВАР ЗУРАГ

Багц - 1		
1	**Бомбер** 	

2	**Зуны хүрэм** **ЗУНЫ ЭРЭГТЭЙ ХҮРЭМ** **ЗАГВАРЫН ДУГААР:** 3-01 **ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:** Дулааны улиралд зуны өмд, жинсэн өмдтэй хослуулан өмсөнө. **ӨНГӨНИЙ КОД:** Мөнгөлөг: Silver Metallic (Pantone 877 C) Хөх: Blueprint (Pantone 19-3939 TPX) Шар: Saffron (Pantone 14-1064 TPX)	**ЗУНЫ ЭМЭГТЭЙ ХҮРЭМ** **ЗАГВАРЫН ДУГААР:** 3-03 **ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:** Дулааны улиралд зуны өмд, жинсэн өмдтэй хослуулан өмсөнө. **ӨНГӨНИЙ КОД:** Мөнгөлөг: Silver Metallic (Pantone 877 C) Хөх: Blueprint (Pantone 19-3939 TPX) Шар: Saffron (Pantone 14-1064 TPX)
3	**Даавуун өмд** **ЗУНЫ МӨРӨВЧТЭЙ ӨМД** **ЗАГВАРЫН ДУГААР:** 3-05 **ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:** Дулааны улиралд зуны хүрэмтэй хослуулан өмсөнө.  **ӨНГӨНИЙ КОД:** Мөнгөлөг: Silver Metallic (Pantone 877 C) Хөх: Blueprint (Pantone 19-3939 TPX) Шар: Saffron (Pantone 14-1064 TPX)	**ЗАГВАРЫН ДУГААР:** 3-04 **ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:** Дулааны улиралд зуны хүрэмтэй хослуулан өмсөнө. **ӨНГӨНИЙ КОД:** Мөнгөлөг: Silver Metallic (Pantone 877 C) Хөх: Blueprint (Pantone 19-3939 TPX) Шар: Saffron (Pantone 14-1064 TPX)

4	**Жийнсэн өмд, Зуны комбинезон** **ЖИНСЭН ӨМД** **ЗАГВАРЫН ДУГААР:** 3-06 **ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:** Дулааны улиралд зуны хүрэмтэй хослуулан өмсөнө. **өнгөний код:** Мөнгөлөг: Silver Metallic (Pantone 877 C) Хөх: Blueprint (Pantone 19-3939 TPX) Шар: Saffron (Pantone 14-1064 TPX)	**ЗУНЫ КОМБИНЕЗОН** **ЗАГВАРЫН ДУГААР:** 3-07 **ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:** Дулааны улиралд футболктай хослуулан өмсөнө. **өнгөний код:** Мөнгөлөг: Silver Metallic (Pantone 877 C) Хөх: Blueprint (Pantone 19-3939 TPX) Шар: Saffron (Pantone 14-1064 TPX)
5	**Ажлын цамц** **АЖЛЫН ЭРЭГТЭЙ ЦАМЦ** **ЗАГВАРЫН ДУГААР:** 3-08 **ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:** Дулааны улиралд зуны өмд, жинсэн өмдтэй хослуулан өмсөнө. **өнгөний код:** Мөнгөлөг: Silver Metallic (Pantone 877 C) Хөх: Blueprint (Pantone 19-3939 TPX) Шар: Saffron (Pantone 14-1064 TPX)	**АЖЛЫН ЭМЭГТЭЙ ЦАМЦ** **ЗАГВАРЫН ДУГААР:** 3-09 **ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:** Дулааны улиралд зуны өмд, жинсэн өмдтэй хослуулан өмсөнө. **өнгөний код:** Мөнгөлөг: Silver Metallic (Pantone 877 C) Хөх: Blueprint (Pantone 19-3939 TPX) Шар: Saffron (Pantone 14-1064 TPX)

6	**Нимгэн цамц /поло/, Поло подволк** **ЗАГВАРЫН ДУГААР:** 3-10 **ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:** Дулааны улиралд зуны өмд, жинсэн өмдтэй хослуулан өмсөнө. **өнгөний код:** Мөнгөлөг: Silver Metallic (Pantone 877 C) Хөх: Blueprint (Pantone 19-3939 TPX) Шар: Saffron (Pantone 14-1064 TPX)	**БОГИНО ХАНЦУЙТАЙ, ЗАХТАЙ ФУТБОЛК** **ЗАГВАРЫН ДУГААР:** 3-11 **ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:** Дулааны улиралд зуны өмд, жинсэн өмдтэй хослуулан өмсөнө. **өнгөний код:** Мөнгөлөг: Silver Metallic (Pantone 877 C) Хөх: Blueprint (Pantone 19-3939 TPX) Шар: Saffron (Pantone 14-1064 TPX)
Багц - 2		
1	**Өвлийн хүрэм** **ЗАГВАРЫН ДУГААР:** 3-15 **ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:** Хүйтний улиралд хантааз, өвлийн мөрөвчтэй, мөрөвчгүй өмдтэй хослуулан өмсөнө. **өнгөний код:** Мөнгөлөг: Silver Metallic (Pantone 877 C) Хөх: Blueprint (Pantone 19-3939 TPX) Шар: Saffron (Pantone 14-1064 TPX)	**ЗАГВАРЫН ДУГААР:** 3-15 **ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:** Хүйтний улиралд хантааз, өвлийн мөрөвчтэй, мөрөвчгүй өмдтэй хослуулан өмсөнө. **өнгөний код:** Мөнгөлөг: Silver Metallic (Pantone 877 C) Хөх: Blueprint (Pantone 19-3939 TPX) Шар: Saffron (Pantone 14-1064 TPX)

2	**Өвлийн өмд** **ӨВЛИЙН МӨРӨВЧТЭЙ ӨМД** **ЗАГВАРЫН ДУГААР:** 3-17 **ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:** Хүйтний улиралд хантааз, өвлийн хүрэмтэй хослуулан өмсөнө. **ӨНГӨНИЙ КОД:** Мөнгөлөг: Silver Metallic (Pantone 877 C) Хөх: Blueprint (Pantone 19-3939 TPX) Шар: Saffron (Pantone 14-1064 TPX)	**ӨВЛИЙН МӨРӨВЧГҮЙ ӨМД** **ЗАГВАРЫН ДУГААР:** 3-18 **ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:** Хүйтний улиралд хантааз, өвлийн хүрэмтэй хослуулан өмсөнө.  **ӨНГӨНИЙ КОД:** Мөнгөлөг: Silver Metallic (Pantone 877 C) Хөх: Blueprint (Pantone 19-3939 TPX) Шар: Saffron (Pantone 14-1064 TPX)
3	**Зузаан цамц** **ДУЛААН ЦАМЦ** **ЗАГВАРЫН ДУГААР:** 3-14 **ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:** Дулааны улиралд зуны өмд, жинсэн өмд, хүйтний улиралд өвлийн өмдтэй хослуулан өмсөнө. **ӨНГӨНИЙ КОД:** Мөнгөлөг: Silver Metallic (Pantone 877 C) Хөх: Blueprint (Pantone 19-3939 TPX) Шар: Saffron (Pantone 14-1064 TPX)	**ДУЛААН ЦАМЦ** **ЗАГВАРЫН ДУГААР:** 3-14 **ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:** Дулааны улиралд зуны өмд, жинсэн өмд, хүйтний улиралд өвлийн өмдтэй хослуулан өмсөнө. **ӨНГӨНИЙ КОД:** Мөнгөлөг: Silver Metallic (Pantone 877 C) Хөх: Blueprint (Pantone 19-3939 TPX) Шар: Saffron (Pantone 14-1064 TPX)

4	**Зузаан хантааз** **ХАНТААЗ** **ЗАГВАРЫН ДУГААР:** 3-16 **ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:** Хүйтний улиралд өвлийн хүрэм, өвлийн мөрөөчтэй, мөрөөчгүй өмдтэй хослуулан өмсөнө. **ӨНГӨНИЙ КОД:** Мөнгөлөг: Silver Metallic (Pantone 877 C) Хөх: Blueprint (Pantone 19-3939 TPX) Шар: Saffron (Pantone 14-1064 TPX)	**ХАНТААЗ** **ЗАГВАРЫН ДУГААР:** 3-16 **ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:** Хүйтний улиралд өвлийн хүрэм, өвлийн мөрөөчтэй, мөрөөчгүй өмдтэй хослуулан өмсөнө.
5	**Өвлийн комбинезон** **ӨВЛИЙН КОМБИНЕЗОН** **ЗАГВАРЫН ДУГААР:** 3-19 **ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:** Хүйтний улиралд футболктай хослуулан өмсөнө. **ӨНГӨНИЙ КОД:** Мөнгөлөг: Silver Metallic (Pantone 877 C) Хөх: Blueprint (Pantone 19-3939 TPX) Шар: Saffron (Pantone 14-1064 TPX)	**ӨВЛИЙН КОМБИНЕЗОН** **ЗАГВАРЫН ДУГААР:** 3-19 **ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:** Хүйтний улиралд футболктай хослуулан өмсөнө. **ӨНГӨНИЙ КОД:** Мөнгөлөг: Silver Metallic (Pantone 877 C) Хөх: Blueprint (Pantone 19-3939 TPX) Шар: Saffron (Pantone 14-1064 TPX)